

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/52/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	<b>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг</b> Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:Naranchimegts@audit.gov.mn">Naranchimegts@audit.gov.mn</a> <b>Аудитын менежер: Ч.Болд</b> Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:Boldch@audit.gov.mn">Boldch@audit.gov.mn</a> <b>Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг</b> Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:Erdenetsetsegi@audit.gov.mn">Erdenetsetsegi@audit.gov.mn</a> <b>Аудитор: А.Баясгалан</b> Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:Bayasgalana@audit.gov.mn">Bayasgalana@audit.gov.mn</a>
--------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ, ТӨРИЙН  
ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨГЧ  
Б.БИЛГҮТЭ ТАНАА

2024.03.15 № 07/734  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 21.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журамтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ нь 2023 онд "Welcome to Mongolia" зорилтот ажлын хүрээнд Тавтай морил нөлөөллийн ажлыг дотоод болон гадаад улсад таниулан түгээж, тараах ажлыг голчлон зохион байгуулж ажиллажээ.

### Аудитын гол асуудал

Аялал жуулчлалын салбарын хүрээнд Монгол Улсад болох арга хэмжээг сурталчлах, эх орны үзэсгэлэнтэй байгалийг танилцуулах, Welcome to Mongolia нөлөөллийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг хийж, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг орнуудтай хамтран аялал жуулчлалын форумуудыг зохион байгуулсан байна.

## Бусад асуудлын хэсэг

Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар "Төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах тухай" тогтоол гарсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	24,478,915.69	162,003,946.43
1.1.2	Дансны авлага	634,117.65	0.00
1.1.6	Бараа материал	1,619,000.00	8,469,000.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	1,008,755,981.00	452,496,981.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,035,488,014.34</b>	<b>622,969,927.43</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	76,389,459.91	51,332,229.75
1.2.2	Биет бус хөрөнгө	202,600.00	132,825,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>76,592,059.91</b>	<b>184,157,229.75</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,112,080,074.25</b>	<b>807,127,157.18</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1.1	Дансны өглөг	172,097,954.72	126,183,348.85
2.1.1.2	Цалингийн өглөг	46,137,426.49	556,709.32
2.1.1.3	Татварын өр	23,824,627.91	22,286,075.37
2.1.1.4	НДШ - ийн өглөг	32,429,197.56	36,599,818.95
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,390,056,263.65	1,059,100,393.65
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,664,545,470.33</b>	<b>1,244,726,346.14</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,664,545,470.33</b>	<b>1,244,726,346.14</b>
<b>2.3</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.3.1	Өмч: - төрийн	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(552,465,396.08)	(437,599,188.96)
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>(552,465,396.08)</b>	<b>(437,599,188.96)</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>1,112,080,074.25</b>	<b>807,127,157.18</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	1,128,962,724.00	<b>3,620,175,280.00</b>
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	983,324,333.14	3,209,324,762.92
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>145,638,390.86</b>	<b>410,850,517.08</b>
8	Бусад орлого	0.00	644,838,610.56
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0.00	483,334,385.41
12	Бусад зардал		512,013,610.56
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	(203,636.00)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(15,000.00)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-145,638,390.86</b>	<b>60,122,495.67</b>
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-145,638,390.86</b>	<b>60,122,495.67</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>-145,638,390.86</b>	<b>60,122,495.67</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>-145,638,390.86</b>	<b>60,122,495.67</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаавар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				(364,636,183.33)	(364,636,183.33)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(187,829,212.75)	(187,829,212.75)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				(552,465,396.08)	(552,465,396.08)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				54,743,711.45	54,743,711.45
Залруулсан үлдэгдэл				(497,721,684.63)	(497,721,684.63)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				60,122,495.67	60,122,495.67
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				(437,599,188.96)	(437,599,188.96)

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>921,524,332.00</b>	<b>3,925,375,910.00</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	921,263,894.00	3,274,623,910.00
Татаас, санхүүжилтын орлого	0.00	632,477,000.00
Бусад мөнгөн орлого	260,438.00	18,275,000.00
<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>1,276,838,067.20</b>	<b>3,787,533,999.26</b>
Ажиллагчдад төлсөн	110,280,148.66	285,299,174.50
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	6,900,825.92	71,853,926.89
Бараа материал худалдан авахад төлсөн	19,674,873.00	9,305,338.00
Ашиглалтын зардалд төлсөн	16,806,264.07	24,911,712.67
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,256,863.00	8,082,800.00
Хүүний төлбөрт төлсөн	1,050,000.00	0.00
Татварын байгууллагад төлсөн	8,376,081.09	24,896,636.42
Даатгалын төлбөрт төлсөн	98,010.00	10,858,110.00
Бусад мөнгөн зарлага	1,108,395,001.46	3,352,326,300.78
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-355,313,735.20</b>	<b>137,841,910.74</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>57,048,946.52</b>	<b>0.00</b>
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	57,048,946.52	0.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>6,636,077.50</b>	<b>308,000.00</b>
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	308,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	6,636,077.50	0.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>50,412,869.02</b>	<b>(308,000.00)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>94,960,000.00</b>	<b>0.00</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	94,960,000.00	0.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>38,859,441.48</b>	<b>0.00</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-266,041,424.70</b>	<b>137,533,910.74</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>290,520,340.39</b>	<b>24,478,915.69</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>24,478,915.69</b>	<b>162,003,946.43</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Нийт орлого</b>	мян.төг	<b>1,128,962.7</b>	<b>2,276,487.0</b>	<b>4,265,013.9</b>	<b>1,988,526.9</b>	<b>187.4</b>
1.1	Эрх шилжүүлэх ажлын орлого	мян.төг	1,127,286.0	2,276,487.0	3,620,175.3	<b>1,343,688.3</b>	<b>159.0</b>
1.3	Бусад орлого	мян.төг	1,676.7		644,838.6	644,838.6	
<b>2</b>	<b>Нийт зардал</b>	мян.төг	<b>1,316,791.9</b>	<b>2,261,487.0</b>	<b>4,204,891.4</b>	<b>1,943,404.4</b>	<b>185.9</b>
<b>2</b>	<b>ББӨ</b>	мян.төг	<b>1,316,791.9</b>	<b>2,261,487.0</b>	<b>3,209,324.8</b>	<b>947,837.8</b>	<b>141.9</b>
2.1	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	332,467.6	929,903.6	483,334.4	<b>-446,569.2</b>	<b>52.0</b>
2.2	Бусад зардал	мян.төг			512,232.2	512,232.2	
<b>3</b>	<b>Татварын өмнөх ашиг, алдагдал</b>	мян.төг	<b>-187,829.2</b>	<b>15,000.0</b>	<b>60,122.5</b>	<b>45,122.5</b>	<b>400.8</b>
<b>4</b>	<b>Цэвэр ашиг (алдагдал)</b>	мян.төг	<b>-187,829.2</b>	<b>13,500.0</b>	<b>60,122.5</b>	<b>46,622.5</b>	<b>445.4</b>
5	Төсвийн нийт төлбөр		23,249.9	205,375.0	40,224.8	<b>-165,150.2</b>	<b>19.6</b>
6	Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	0.0	2,025.0		<b>-2,025.0</b>	<b>0.0</b>
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	14.0	21.0	21.0	<b>0.0</b>	<b>100.0</b>
8	Нийт цалингийн сан	мян.төг	193,044.8	695,027.2	324,575.4	<b>-370,451.8</b>	<b>46.7</b>
9	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,149.1	2,758.0	1,288.0	<b>-1,470.0</b>	<b>46.7</b>
10	Нийт хөрөнгө оруулалт	мян.төг	0.0	25,085.0	4,570.1	<b>-20,514.9</b>	<b>18.2</b>
11	Нийт авлага	мян.төг	634.1	634.1	0.0	<b>-634.1</b>	<b>0.0</b>
12	Нийт өглөг	мян.төг	274,489.2	48,900.0	185,626.0	<b>136,726.0</b>	<b>379.6</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,309.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гэрээгээр хийсэн ажил нь дуусаж, актаар хүлээлцсэн урьдчилж орсон орлого, зардал дансны гүйлгээг тайлант үеийн орлого, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй	2	2,219.0			2	2,219.0	2	2,219.0				
Үр дүнгийн тайланд 54.7 сая, мөнгөн гүйлгээний тайланд 35.4 сая төгрөг нийт 90.1 сая төгрөгийн орлого илүү тайлагнасан.	1	90.1			1	90.1	1	90.1				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,309.1</b>			<b>3</b>	<b>2,309.1</b>	<b>3</b>	<b>2,309.1</b>				

Аудитаар нийт 675.0 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлага, 1 зөвлөмж өгөв.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өр төлбөр дансанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжид 58.5 сая, хувь хүмүүст 67.7 сая төгрөг, цалингийн 0.6 сая төгрөг, татварын 22.3 сая төгрөг, НДШ-ийн 36.6 сая төгрөг, нийт 185.6 сая төлбөрийн өр төлбөрийг барагдуулаагүй.	1	185.6			1	185.6						

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын хураангуй тайлан**

Хөтөлбөр арга хэмжээний зардлаас байгууллагын үйл ажиллагааны зардалд 28.6 сая төгрөг, Бүгд найрамдах Солонгос Улсад К поп арга хэмжээ зохион байгуулах, уулзалт хийх томилолтын зардалд 32.4 сая төгрөг, нийт 61.0 сая төгрөгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан.	1	61.0			1	61.0				
А ..ХХК-тай 2022 онд ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж 29.4 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон боловч гэрээт ажил хийгдээгүй.	1	29.4			1	29.4				
Япон-Монголын шууд нислэг хийсэнтэй холбоотой угтах үйлчилгээ хийж 9.9 сая төгрөг, нэр бүхий 13 хэвлэл, мэдээллийн байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, санхүүжилт олгосон 48.3 сая төгрөг, нийт 58.2 сая төгрөгийн үрэлгэн зардал гаргасан.	1	58.2			1	58.2				
ТӨААТҮГ-ын зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тусгагдаагүй зардал гаргасан.	1	314.5			1	314.5				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>648.7</b>			<b>5</b>	<b>648.7</b>				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3,100.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2,779.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 320.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Худалдан авах босго үнээс давсан өртөг бүхий 14 ажил үйлчилгээ буюу нийт 2,779.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг тендер зарлаж сонгон шалгаруулалт хийгээгүй, шууд гэрээ байгуулж, зарцуулсан.	1	2,779.9			1	2,779.9			
Өмнөх оны аудитаар тогтоосон 320.8 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулаагүй.	1	320.8					1	320.8	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,100.7</b>			<b>1</b>	<b>2,779.9</b>		<b>1</b>	<b>320.8</b>